БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагааннуур тосгоны ЭМТ-ийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2024/146/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2023 он	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Ж.Айгүл Утас: 70422954 Цахим хаяг: Aigulj@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Ахлах аудитор: М.Айнур Утас: 94159291 Цахим хаяг: ainurm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан .....
4.1 Ерөнхий зүйл .....
4.2 Материаллаг байдал .....
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2024.02.23 № 240
танай _____-ны № _____-т

ЦАГААННУУР ТОСГОНЫ ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Т.БАГИЛАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

Аудитын гол асуудал

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал

00402055

байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГҮЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	**ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН**	**68,813,930.09**	**89,977,064.62**
31	**МӨНГӨН ХӨРӨНГӨ**	3,937,363.16	11,911,624.35
311	**Кассанд байгаа бэлэн мөнгө**	-	-
31110	Төгрөг	-	-
31120	Гадаад валют	-	-
31130	Нэмэлт санхүүжилт	-	-
31140	Касс арилжааны банк	-	-
312	**Банкинд байгаа бэлэн мөнгө**	3,937,363.16	11,911,624.35
3121	**Төгрөг**	3,937,363.16	11,911,624.35
31211	Төрийн сангийн харилцах	3,937,363.16	11,911,624.35
31212	Монгол банкин дахь харилцах	-	-
31213	Арилжааны банк дахь харилцах	-	-
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	-	-
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк	-	-
33	**АВЛАГА**	-	9,047,195.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	180,002.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	8,867,193.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	-
33400	Зээлийн хүүгийн авлага	-	-
35	**БАРАА МАТЕРИАЛ**	64,876,566.93	69,018,245.27
351	**Түүхий эд материал**	42,172,543.36	38,036,917.50
35110	Тусгай зориулалттай материал	-	-
35130	Эм боох материал	42,172,543.36	38,036,917.50
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	-	-
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	-
354	**Хангамжийн материал**	22,704,023.57	30,981,327.77
35410	Бичиг хэргийн материал	60,000.00	1,315,300.00
35420	Аж ахуйн материал	10,423,444.00	16,789,222.20
35430	Сэлбэг хэрэгсэл	-	-
35440	Түлш, шатах тослох материал	220,000.00	220,000.00
35450	Барилгын засварын материал	-	-
35460	Хүнсний материал	547,800.00	1,204,026.00
35470	Бусад хангамжийн материал	11,452,779.57	11,452,779.57
35500	Биологийн хөрөнгө	-	-
35600	Мал амьтад	-	-
2	**ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН**	**138,002,686.68**	**169,506,891.04**
39	**ҮНДСЭН ХӨРӨНГӨ**	138,002,686.68	169,506,891.04
391	Газар	-	-
392	**Биет хөрөнгө**	130,686,686.68	162,190,891.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	81,858,113.00	81,858,113.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(18,983,444.18)	(26,213,447.30)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	50,532,143.00	50,532,143.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(34,782,143.00)	(40,032,143.00)

39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	80,166,705.69	141,010,484.69
39206	Хуримтлагдсан элэгдэл	(39,372,971.57)	(53,137,375.77)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,501,784.00	23,501,784.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,583,291.40)	(16,417,625.44)
39209	Зам, гүүрийн байгууламж	-	-
39210	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	-	-
39212	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	-	-
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,784,000.00	11,784,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(9,434,208.86)	(10,695,042.14)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	-
39217	Ном	-	-
393	**Биет бус хөрөнгө**	7,316,000.00	7,316,000.00
39301	Програм хангамж	600,000.00	600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(600,000.00)	(600,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,316,000.00	7,316,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	-
3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II**	**206,816,616.77**	**259,483,955.66**
4	**НИЙТ ӨР ТӨЛБӨР**	**34,399.00**	**-**
41	**БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР**	34,399.00	-
413	**Өглөг**	34,399.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	34,399.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	-	-
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	-	-
41350	Зээлийн хүүгийн өглөг	-	-
5	**ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН**	**206,782,217.77**	**259,483,955.66**
51	**Засгийн газрын хувь оролцоо**	206,782,217.77	259,483,955.66
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	125,246,528.00	125,246,528.00
51101	Өмч: - төрийн	125,246,528.00	125,246,528.00
51102	- хувийн	-	-
51103	- хувьцаат	-	-
51104	Халаасны хувьцаа	-	-
51105	Нэмж төлөгдсөн капитал	-	-
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
512	**Хуримтлагдсан үр дүн**	49,414,789.77	102,116,527.66
51210	Өмнөх үеийн үр дүн	49,414,789.77	49,414,789.77
51220	Тайлант үеийн үр дүн	-	52,701,737.89
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	-	-
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	32,120,900.00	32,120,900.00
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	-	-
51600	Нөөцийн сан	-	-
6	**ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V**	**206,816,616.77**	**259,483,955.66**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)**	**452,375,894.12**	**524,889,583.90**
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	**43,224,464.12**	**86,510,647.20**
120	**Нийтлэг татварын бус орлого**	43,224,464.12	86,510,647.20
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	43,224,464.12	20,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	20,000,000.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	-	-
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	-	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	43,224,464.12	-
120005	Түрээсийн орлого	-	-
120006	Газрын тосны орлого	-	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	60,443,779.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	6,066,868.20
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**409,151,430.00**	**438,378,936.70**
1320	**Орон нутгийн төсвөөс санхүүжих**	12,032,500.00	18,414,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	12,032,500.00	18,414,500.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	-	-
1340	**Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих**	397,118,930.00	419,964,436.70
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	397,118,930.00	419,964,436.70
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	-	-
2	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН**	**410,412,694.04**	**472,187,846.01**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**410,412,694.04**	**472,187,846.01**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	410,412,694.04	472,187,846.01
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	260,265,248.60	322,184,455.81
210101	Үндсэн цалин	163,982,709.70	265,469,477.21
210102	Нэмэгдэл	52,489,810.91	40,433,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,536,000.00	4,328,996.55
210104	Урамшуулал	12,452,980.18	11,952,082.05
210105	Гэрээт ажлын хөлс	26,803,747.81	-
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	34,718,100.00	43,606,901.00
210201	Тэтгэврийн даатгал	23,658,800.00	29,676,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,764,600.00	3,491,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,212,100.00	2,793,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	552,600.00	697,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,530,000.00	6,948,501.00
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	11,881,900.00	16,627,390.00
210301	Гэрэл, цахилгаан	2,372,402.12	1,839,504.00
210302	Түлш, халаалт	8,922,983.44	13,668,886.00
210303	Цэвэр, бохир ус	586,514.44	1,119,000.00
210304	Байрны түрээс	-	-
2104	**Хангамж, бараа материалын зардал**	23,974,863.00	24,012,425.00
210401	Бичиг хэрэг	1,972,000.00	2,009,600.00

210402	Тээвэр, шатахуун	18,354,313.00	18,849,925.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,272,650.00	587,200.00
210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	214,400.00	444,110.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,161,500.00	377,400.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	1,744,190.00
210408	Бараа материал акталсны зардал	-	-
2105	**Норматив зардал**	44,622,475.00	32,715,949.56
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	33,953,978.00	27,712,325.56
210502	Хоол, хүнс	9,418,497.00	4,491,624.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,250,000.00	512,000.00
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	3,475,200.00	1,413,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	626,300.00	213,200.00
210602	Тавилга	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-
210604	Урсгал засвар	2,848,900.00	1,200,000.00
2107	**Томилолт, зочны зардал**	910,000.00	495,300.00
210701	Гадаад албан томилолт	-	-
210702	Дотоод албан томилолт	910,000.00	495,300.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	502,350.00	54,450.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	55,000.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	39,200.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	-
210807	Газрын төлбөр	28,150.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	-
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	30,062,557.44	31,077,774.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,690,712.00	1,738,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,371,845.44	29,339,574.64
210904	Найдваргүй авлагын алдагдал	-	-
3	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)**	**41,963,200.08**	**52,701,737.89**
4	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)**	-	-
5	**НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)**	**41,963,200.08**	**52,701,737.89**

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/Төгрөгөөр/
Дансны код	**Үзүүлэлт**	**Өмнөх оны гүйцэтгэл**	**Тайлант оны гүйцэтгэл**
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)**	**409,151,430.00**	**449,511,743.70**

12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	**-**	**20,000,000.00**
120	**Нийтлэг татварын бус орлого**	-	20,000,000.00
120001	Хувьцааны ногдол ашиг		
120002	Хүүгийн орлого		
120003	Торгуулийн орлого		
120004	**Төсөв байгууллагын өөрийн орлого**	-	20,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		20,000,000.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**409,151,430.00**	**429,511,743.70**
1320	**Орон нутгийн төсвөөс санхүүжих**	12,032,500.00	18,414,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	12,032,500.00	18,414,500.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт		
1340	**Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих**	397,118,930.00	411,097,243.70
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	397,118,930.00	411,097,243.70
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		
2	**НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)**	**405,214,067.84**	**441,137,482.51**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**405,214,067.84**	**441,137,482.51**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**405,214,067.84**	**441,137,482.51**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	262,390,150.84	322,364,457.81
210101	Үндсэн цалин	156,616,796.62	265,622,475.76
210102	Нэмэгдэл	60,843,435.23	40,433,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,989,000.00	4,356,000.00
210104	Урамшуулал	11,562,534.18	11,952,082.05
210105	Гэрээт ажлын хөлс	30,378,384.81	
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	31,773,400.00	43,641,300.00
210201	Тэтгэврийн даатгал	21,606,300.00	29,676,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,541,600.00	3,491,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,033,600.00	2,793,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	508,000.00	697,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,083,900.00	6,982,900.00
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	9,979,400.00	16,627,390.00
210301	Гэрэл, цахилгаан	1,813,200.00	2,577,200.00
210302	Түлш, халаалт	7,200,000.00	12,768,000.00
210303	Цэвэр, бохир ус	966,200.00	1,282,190.00
210304	Байрны түрээс		
2104	**Хангамж, бараа материалын зардал**	27,633,800.00	22,374,435.00
210401	Бичиг хэрэг	2,315,100.00	1,850,000.00
210402	Тээвэр, шатахуун	20,700,700.00	18,849,925.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	961,900.00	587,200.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	493,200.00	444,110.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,162,900.00	643,200.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		

210408	Бараа материал акталсны зардал		
2105	**Норматив зардал**	63,673,866.00	29,531,549.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	53,894,200.00	24,675,701.70
210502	Хоол, хүнс	8,404,666.00	4,048,848.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,375,000.00	807,000.00
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	4,324,400.00	3,139,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	791,500.00	613,200.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	3,532,900.00	2,526,100.00
2107	**Томилолт, зочны зардал**	910,000.00	495,300.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	910,000.00	495,300.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	502,350.00	54,450.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	55,000.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	39,200.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		
210807	Газрын төлбөр	28,150.00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	4,026,701.00	2,909,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,026,701.00	2,909,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
3	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)**	**3,937,362.16**	**8,374,261.19**
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)**	**-**	**400,000.00**
22	**ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ**	**-**	**400,000.00**
2200	**Дотоод эх үүсвэрээр**	-	400,000.00
220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		
222001	Тоног төхөөрөмж		
223001	Бусад хөрөнгө		
224001	Стратегийн нөөц хөрөнгө		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		400,000.00
6	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)**	**-**	**(400,000.00)**
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	**САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ**	**-**	**-**
8	**НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)**	3,937,362.16	7,974,261.19

9	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**	1.00	3,937,363.16
10	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**	3,937,363.16	11,911,264.35

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	**2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл**				0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	**Дахин илэрхийлсэн үлдэгдэл**	**125,246,528.00**	**32,120,900.00**	**-80,449,409.99**	76,918,018.01
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			31,342,512.89	31,342,512.89
C08	**2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**125,246,528.00**	**32,120,900.00**	**-49,106,897.10**	108,260,530.90
D01	**2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл**	**125,246,528.00**	**32,120,900.00**	**-49,106,897.10**	108,260,530.90
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	**Дахин илэрхийлсэн үлдэгдэл**	**0.00**	**0.00**	**0.00**	0.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	125,246,528.00	32,120,900.00	49,414,789.77	206,782,217.77
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			52,701,737.89	52,701,737.89
D09	**2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**125,246,528.00**	**32,120,900.00**	**102,116,527.66**	259,483,955.66

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	**Үзүүлэлт**	**Тайлант оны**	
		Батлагдсан төлөвлөгөө	**Гүйцэтгэл**
1	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**		

2	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	495,921,800.00	441,537,482.51
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	495,921,800.00	441,537,482.51
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	495,921,800.00	441,537,482.51
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	359,194,000.00	322,364,457.81
210101	Үндсэн цалин	270,818,100.00	265,622,475.76
210102	Нэмэгдэл	40,433,900.00	40,433,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,356,000.00	4,356,000.00
210104	Урамшуулал	43,586,000.00	11,952,082.05
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	43,641,300.00	43,641,300.00
210201	Тэтгэврийн даатгал	29,676,000.00	29,676,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,491,200.00	3,491,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,793,300.00	2,793,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	697,900.00	697,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,982,900.00	6,982,900.00
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	16,361,400.00	16,361,400.00
210301	Гэрэл, цахилгаан	2,577,200.00	2,577,200.00
210302	Түлш, халаалт	12,768,000.00	12,768,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,016,200.00	1,016,200.00
210304	Байрны түрээс		
2104	**Хангамж, бараа материалын зардал**	26,274,900.00	22,640,425.00
210401	Бичиг хэрэг	1,850,000.00	1,850,000.00
210402	Тээвэр, шатахуун	22,111,900.00	18,849,925.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	920,100.00	793,900.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	749,700.00	503,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	643,200.00	643,200.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	**Норматив зардал**	38,634,800.00	29,531,549.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,763,200.00	24,675,701.70
210502	Хоол, хүнс	4,839,600.00	4,048,848.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,032,000.00	807,000.00
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	5,720,400.00	3,139,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	917,300.00	613,200.00
210602	Тавилга	2,000,000.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	2,803,100.00	2,526,100.00
2107	**Томилолт, зочны зардал**	495,300.00	495,300.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	495,300.00	495,300.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	142,300.00	54,450.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ	55,000.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	39,200.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		
210807	Газрын төлбөр	28,100.00	

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	5,457,400.00	3,309,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,457,400.00	3,309,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
211	**ХҮҮ**	-	-
2111	**Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр**	-	-
211101	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр		
2112	**Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр**	-	-
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр		
212	**ТАТААС**	-	-
2121	**Төрийн өмчит байгууллагад олгох татаас**	-	-
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас		
2122	**Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас**	-	-
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас		
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	-	-
2131	**Засгийн газрын урсгал шилжүүлэг**	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	-	-
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
22	**ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ**	-	-
2200	**Дотоод эх үүсвэрээр**	-	-
220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		
222001	Тоног төхөөрөмж		
223001	Бусад хөрөнгө		
224001	Стратегийн нөөц хөрөнгө		
2260	**Гадаад эх үүсвэрээр**	-	-
226001	Гадаад эх үүсвэрээр		
23	**ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ**	-	-
230001	Эргэж төлөгдөх зээл		
231001	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл		
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл		
13	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**	495,921,800.00	449,511,743.70
1310	**УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	-	-
131001	Улсын төсвөөс санхүүжих		
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих		
1320	**ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	18,414,500.00	18,414,500.00

132001	Орон нутгийн төсвөөс	18,414,500.00	18,414,500.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
1340	**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	447,695,500.00	411,097,243.70
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	447,695,500.00	411,097,243.70
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		
120004	**ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС**	29,811,800.00	20,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,874,500.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,000.00	20,000,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	3,937,300.00	
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		
122	**ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ**	-	-
122001	Хандив тусламж /дотоод/		
122002	Хандив тусламж /гадаад/		
14	**БУСАД ЭХ ҮҮСВЭР**	-	-
145005	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх		
4	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**	3,937,363.16	
5	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**	11,911,624.35	
6	**ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ**		
61	**БАЙГУУЛЛАГЫН ТОО**	-	-
610001	Төсвийн байгууллага		
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	**АЖИЛЛАГСАДЫН ТОО**	21.00	21.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00
620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00
620004	Гэрээт ажилтан		
65	**ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ**	**21.00**	**21.00**
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)		
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)		
650003	Ажлын албаны албан хаагч (АА)		
650004	СЄБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)		
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)		
650006	Соёл урлагийн салбарын төрийн їйлчилгээний албан хаагч (ТҮСУ)		
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)		
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	16.00	16.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5.00	5.00
650010	Гэрээт ажилтан		
650011	Улс төрийн албан хаагч (УТ)		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Байхгүй

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төв нь тосгоны иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллага.

Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төвийн тайлант оны зорилгыг “Үйлчлэх хүрээний хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тусламж, үйлчилгээг жигд хүртээмжтэй, чанартай үзүүлэх, замаар тэдний эрүүл мэндийн түвшинг сайжруулахад оршино“ гэж тодорхойлсон байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төв 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийгдсэн байна. 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд ямар нэгэн хяналт шалгалт, аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төв нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны 03 сарын 15-ны өдрийн А/10 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн,* тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 52.7 сая төгрөгөөр буюу 1.25 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3937.3	11,911.60	-7974.3
Авлага	0	9,047.20	-9047.2
Урьдчилгаа			
Бараа материал	64,876.60	69,018.20	-4,141.60
Үндсэн хөрөнгө	138,002.70	169,506.90	-31,504.20
Нийт хөрөнгө	**206,816.60**	**259,483.90**	-52,667.30
Өр төлбөр	34.4	-	
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	206,782.20	259,483.90	-52,701.70
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	**206,816.60**	**259,483.90**	-52,667.30

Дээрх хүснэгтээс харахад үндсэн хөрөнгө, өглөг дансанд өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө данс оны эцэст 11.9 сая төгрөгийг үлдэгдэлтэй гарсан.

Авлага дансны үлдэгдэл 9.0 сая төгрөг болж нэмэгдсэн байна. Эрүүл мэндийн даатгалын сангаас 8.9 сая төгрөгийн санхүүжилтийн авлага, ХХОАТ-ын 0.2 сая төгрөгийн авлагыг шинээр нэмэгдсэн байна.

Бараа материалын үлдэгдэл 4.1 сая төгрөгөөр нэмэгдсэн.Төсвийн хөрөнгөөр 34.0 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 6.1 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, 36.0 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 69.0 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй гарсан байна.Акталсан бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 31.5 сая төгрөгөөр өссөн.Төсвийн хөрөнгөөр 0.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авч, бусад эх үүсвэрээр нийт 60.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авсан байна. Шилжүүлсэн буюу акталсан хөрөнгө байхгүй байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант үеийн үр дүнгээр 52.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 368.3 сая төгрөгөөр, нийт зарлагыг 368.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж Төсвийн төслийн саналаас 127.6 сая төгрөгөөр бууруулан, 495.9 сая төгрөгөөр батлсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс 447.7 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 18.4 сая төгрөгийн санхүүжилтийг авч, өөрийн үйл ажиллагааны орлогоос 25.9 сая төгрөгийн бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 411.1 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 18.4 сая төгрөгийн санхүүжилтийг авч, туслах үйл ажиллагааны орлогоос 20.0 сая төгрөгийн орлогыг оруулсан байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 441.5 сая төгрөг буюу 89.0 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
80302	Нэг иргэнд ногдох нормативаар	312,792.40	274,383.10	38,409.30	87.72
81603	Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	134,903.10	130,135.80	4,767.30	96.47

83603	Төсөвт байгууллагын өөрийн орлого	29,811.80	18,604.00	11,207.80	62.40
80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	18,414.50	18,414.50	-	100.00
	Дүн	495,921.80	441,537.40	54,384.40	89.03

Тайлант онд төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө байхгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төв нь тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төв нь 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төв нь худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна.Батлагдсан төсвийн хүрээнд 34.0 сая төгрөгийн бараа материал, 0.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төв нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Айнур гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 07 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 276.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 4.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 472.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 7.1 сая төгрөг болж байна.

Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төвийн нийт орлого, зардалд өмнөх оноос өөрчлөлт орсон байх тул материаллаг байдлыг гүйцэтгэлийн шатанд шинээр тогтоох нь зохимжтой гэж үзлээ.

44.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтийн хангаж ажилласан байна. Төсвийн хөрөнгөөр 0.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бэлтгэсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгав.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 51.5 сая төгрөгийн 3 мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна. Шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 71.7 хувьтай байна. Төсөв, мөнгө, хөрөнгөтэй холбоотой 2 шийдвэрийг оруулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 51.5 сая төгрөгийн 3 мөнгөн гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй зөрчилд албан шаардлага өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төвийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийсэн.Аудитаар уулзалт хийж, байгууллагын талаар мэдээлэл, дотоод аудитын талаар мэдээлэл авч, холбогдох ажлын баримтуудыг цуглуулсан. Нөлөөллийн мэдүүлгийн баримтыг танилцуулж, гарын үсэг зуруулж, уулзалтын тэмдэглэлийг баримтжуулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар санхүүгийн тайланд татгалзах дүгнэлт өгсөн.Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд аудит хийлгээгүй эрхлэгчид сахилгын хариуцлага тооцох, нягтлан бодогчийг ажлаас чөлөөлөх албан шаардлага өгөгдсөн бөгөөд албан шаардлагын биелэлтийг хуулийн хугацаанд ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	2	0	2	0	100%
Зөвлөмж					

Нийт дүн	2	0	2	0	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар үзэх анхаарал татах асуудал ажиглагдаагүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 65,256.3 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 65,256.3 мянган төгрөгийн алдааг залруулласан. *Залруулсан алдаа:*

- Татаас санхүүжилтийн 8,867.2 мянган төгрөгийн, ХХОАТ-ын 180.0 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй байсныг залруулав.
- Бараа материалын үлдэгдлийг 17,359.2 мянган төгрөгөөр алдаатай илэрхийлсэн, шатахууны 18,849.9 мянган төгрөгийн бараа материалын нярвын тайланг хөтлөөгүй байсныг аудитын явцад залруулсан.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд үйл ажиллагааны өөрийн орлого 20,000.0 мянган төгрөгийг дээд шатны төсвийн захирагчаас гэсэн ангилалд тусгасныг залруулсан.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлан гаргах заавар аргачлал, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 169,418.3 мянган төгрөгийн зөрчил[2] илэрч, 169,418.3 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар 628.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

Эрүүл мэндийн төвийн их эмч 3 хүнд ажил хавсарч хийгээгүй, тушаал шийдвэр гараагүй байхад 2023 оны 2 сарын цалингийн цэсээр нийт 628.1 мянган төгрөгийн цалинг ажил хавсарч хийснээр илүү олгосныг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэнд нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитаар 51481.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 51,481.6 мянган төгрөгийн 3 мөнгөн гүйлгээг мэдээлээгүй, төсөв, мөнгө, хөрөнгөтэй

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

холбоотой 2 шийдвэрийг оруулаагүй байсан байна. Шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 71.7 хувьтай байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т ”тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 4.1.4-т “хуулийн дагуу нуцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх”, 5 дугаар зүйлийн 5.1.4-т ”мэдээллийг тогтмол шинэчилж байх”, 6 дугаар зүйлийн 6.1-д “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4-т “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4 дэх хэсгийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8-д "..... төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр", 7 дугаар зүйлийн 7.1-д “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ” гэсэн заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын холбогдох заалтуудад нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөгдлөө.

5.3 Зөвлөмж

Аудитаар 14,091.5 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал

1.1.Илрүүлэлт:

Худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд төлсөн бүгд 14,091.5 мянган төгрөгийн гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1, 14.3.2, 14.3.3, 14.4.1, 14.4.5, 14.4.6 дахь заалтууд, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, зааврыг хэрэгжүүлээгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд төлсөн зардлыг тооцооны данс дамжуулан бүртгэж тайлагнах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг үнэн зөв тайлагнаагүй	3	65256.3	0	0	3	65256.3	3	65256.3				
Дүн	5	65256.3	0	0	5	65256.3	5	65256.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам зөрчсөн	2	52109.7	1	628.2								
					1	51481.6						
							1	14,091.5				
Дүн	**2**	**52109.7**	**1**	**628,2**	**1**	**51481.6**	**1**	**14,091.5**				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсан мэдээлээгүй орхигдуулсан	1	14091.5					1	14091.5

Дүн	**1**	**14091.5**					**1**	**14091.5**